*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# СТРАТЕГИ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Б.ЭРДЭНИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. САЛБАРЫН УРТ, ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛНА. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №18. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулна. | Батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, ЦХИХХ-ны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалаар батлуулсан. | 01/02-01/15 | 100 |
| | Дэд арга хэмжээ – 1.1.1: Мандат болон орчны шинжилгээ хийнэ. | Мандат болон орчны шинжилгээний тоо | - | 1 | Стратеги төлөвлөгөөний бүрдэл хэсгүүд болох харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал, стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага, мандатын шинжилгээ, орчны шинжилгээг хийж, зорилго зорилтуудыг тодорхойлсон. | 01/02-01/15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэд арга хэмжээ – 1.1.2: Стратеги төлөвлөгөөний төсөлд холбогдох нэгжүүд болон харьяа байгууллагуудаас санал авна. | Нэгтгэсэн баримт бичгийн тоо | - | 1 | 1. ЗГҮАХ 2024-2028-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ болон холбогдох нэгжүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан.<br>2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индексүүдийн 2024 оны үзүүлэлтүүдийг судалж, зорилтод түвшнийг тодорхойлон холбогдох тайлбаруудыг оруулсан.<br>3. 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр харьяа байгууллагын удирдлагуудад танилцуулж, холбогдох саналыг тусгасан.<br>4. Стратеги төлөвлөгөөг батлуулах тушаалын төслийг боловсруулж, нэгжийн дарга нарт танилцуулж, холбогдох саналуудыг төлөвлөгөөнд тусгасан.<br>5. ХШҮДАГ-аас шалгуур үзүүлэлтийг сайжруулах талаар ирүүлсэн санал тус бүрд шинжилгээ хийж, холбогдох засваруудыг оруулсан. | 01/02-01/15 | 100 |
| ЗОРИЛТ 2. САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО. | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1<br>Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №1.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | ЗГХЭГ-т хүргүүлсэн төслийн тоо | - | - | Тайлант хугацаа болоогүй. | 08/15-09/30 | - |
| | Дэд арга хэмжээ – 2.1.1: Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулна. | Боловсруулсан үзэл баримтлалын төсөл болон | - | 1 | Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийг | 04/01-08/15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуулийн төслийн тоо | | | боловсруулахтай холбогдуулан БНСУ-ын Цахилгаан холбооны эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиудыг судалсан. | | |
| | Дэд арга хэмжээ – 2.1.2: Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийнэ. | Ажлын даалгаврын тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 08/01-08/15 | - |
| | Дэд арга хэмжээ – 2.1.3: Хэлэлцүүлэг зохион байгуулна. | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 08/15-08/30 | - |
| | Дэд арга хэмжээ – 2.1.4: Хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авна. | Нэгтгэсэн баримт бичгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 08/30-09/15 | - |
| 3. | Арга хэмжээ 2.2. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №7. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулна. | Судалгааны тоо | - | 1 | Ажлын хэсгийн 2025 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн хурлаар Ажлын хэсгийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж, санал солилцсон. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу судалгааны асуулгыг боловсруулж, асуулгын хүрээнд 2G болон 3G сүлжээний өнөөгийн байдлын судалгааг хот, аймаг, сум, суурин газрын түвшинд хийж, санал дүгнэлт боловсруулсан. | 02/17-06/30 | 100 |
| | Дэд арга хэмжээ – 2.2.1: Ажлын хэсэг байгуулна. | Ажлын хэсгийн тоо | - | 1 | Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтнуудын саналыг тусган, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлуулсан. Тушаалыг Ажлын хэсгийн | 03/17-05/15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гишүүдэд цахим шуудангаар хүргүүлэн Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 03 дугаар сарын 17 болон 05 дугаар сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулав. | | |
| | Дэд арга хэмжээ – 2.2.2: 2G, 3G технологид суурилсан үйлчилгээг зогсооход баримтлах чиглэлийн төсөл боловсруулна. | Төслийн тоо | - | 1 | Судалгаанд үндэслэн хөдөлгөөнт холбооны 2G болон 3G сүлжээг зогсооход баримтлах чиглэлийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан. | 05/15-06/30 | 100 |
| | Дэд арга хэмжээ – 2.2.3: Төсөлд холбогдох байгууллагуудаас санал авна. | Нэгтгэсэн баримт бичгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 06/30-07/30 | - |
| | Дэд арга хэмжээ – 2.2.4: Төслийг батлуулна. | Батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 08/01-09/30 | - |
| 4. | Арга хэмжээ 2.3.<br>Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №5.Интернэтийн дундын холболтын журам батлуулна. | Батлуулсан баримт бичгийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 10/01-12/15 | - |
| | Дэд арга хэмжээ – 2.3.1: Ажлын даалгавар боловсруулна. | Ажлын даалгаврын тоо | - | 1 | Интернэтийн дундын холболтын журам боловсруулах хүрээнд Ажлын даалгаврыг боловсруулж, ТНБД-аар батлуулсан. Уг ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар гүйцэтгүүлэхээр холбогдох мэдээллийг 2025 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 02/1361 дугаар бичгийг Нат Си Икс Экспертс ХХК, Мэдээлэл холбооны чадавхын хөгжлийн форум ТББ, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци ТББ-д тус тус хүргүүлэв. | 03/20-06/15 | 100 |
| | Дэд арга хэмжээ – 2.3.2: Журмын төсөл боловсруулна. | Боловсруулсан төслийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 09/01-09/30 | - |
| | Дэд арга хэмжээ – 2.3.3: Журмын төсөлд үйлчилгээ эрхлэгчдээс санал авна. | Нэгтгэсэн баримт бичгийн тоо | - | 1 | | 10/01-12/15 | - |
| 5. | Арга хэмжээ 2.4.<br>Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний №6. Монгол Улсын Харилцаа | | ЦХХХ-ны сайдын | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 10/01-12/15 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулна. | Батлуулсан баримт бичгийн тоо | 2024 оны А/29 дүгээр тушаал | | | | |
| | Дэд арга хэмжээ – 2.4.1: Ажлын хэсэг байгуулна. | Ажлын хэсгийн тоо | 0 | 1 | Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг улсын хэмжээнд “112” дугаараар хүлээн авахад шаардлагатай техникийн нөхцөл, системийн тохиргоог үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулан зохион байгуулах, нэгдсэн дугаарлалтад шилжих системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн боловсруулах, хиймэл оюунд суурилсан технологийн шийдлийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/43 дугаар тушаалаар батлуулсан. Тушаалын төсөлд холбогдох албан тушаалтнуудаас санал авч, тусгасан. Мөн Ажлын хэсэгт ажиллах албан тушаалтнуудын нэрс авахаар 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 03/412 дугаар бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | 02/10-02/28 | 100 |
| | Дэд арга хэмжээ – 2.4.2: Туршилтын ажлыг зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | - | 1 | 1.Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав. Уг хурлаар Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг улсын хэмжээнд “112” дугаараар хүлээн авахад шаардлагатай техникийн нөхцөл, системийн тохиргоог хэрхэн гүйцэтгэх талаар санал солилцов. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээллийг бэлтгэж, гишүүдэд цахим шуудангаар хүргүүлсэн.<br>2.“112” дугаараар дуудлага хүлээн авах туршилтыг үүрэн холбооны оператор компаниудыг оролцуулан 2025 оны 04 | 02/28-12/15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 13-ны өдрийн хооронд Төв аймагт зохион байгуулсан. Туршилтын явцын талаарх тайлан, мэдээллийг нэгтгэж, Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулав. | | |
| | Дэд арга хэмжээ – 2.4.3: Төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулна. | Боловсруулсан төсөл, танилцуулгын тоо | - | 2 | Тайлант хугацаа болоогүй. | 09/15-10/15 | - |
| 6. | Арга хэмжээ 2.5. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны бүлгийн Ажлын хэсэгт ажиллаж, Харилцаа холбооны салбарын хэлэлцээрийн хэсэгт санал боловсруулж, хүргүүлнэ. | Саналын тоо | - | 1 | 1.2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ЭЗХЯ, ЦХИХХЯ, ХХЗХ-ны төлөөлөл хуралдаж Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны бүлэгт хамаарах заалт тус бүрийг хэлэлцэж, санал солилцсон.<br>2.Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Үйлчилгээний худалдааны хэлэлцээрийн Харилцаа холбооны хэсэгт санал боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр bujinlkham.e@med.gov.mn цахим шуудангаар ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 01/15-12/15 | 100 |
| 7. | Арга хэмжээ 2.6. Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний нэгдсэн төлөвлөлтийн төсөл боловсруулна. | Төслийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 07/01-12/15 | - |
| ЗОРИЛТ 3.“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 8. | Арга хэмжээ 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулна, тайлагнана. | Батлагдсан төлөвлөгөө, тайлангийн тоо | -<br>- | 1<br>1 | 1.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, батлуулсан.<br>2.Холбогдох журам, аргачлалын дагуу тайлан боловсруулсан. | 01/02-12/30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Арга хэмжээ 3.2.<br>Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Биелэлтийн тоо | - | 1 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг тухай бүр тайлагнаж, удирдлагаас чиглэл авч ажилласан. | 01/02-12/30 | 100 |
| 10. | Арга хэмжээ 3.3.<br>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэнэ. | Шийдвэрлэсэн албан бичгийн тоо | - | - | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон 32 албан бичгийг шийдвэрлэсэн. | 01/02-12/30 | 100 |
| 11. | Арга хэмжээ 3.4.<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | ХАСХОМ-ийн маягт | - | 1 | ХАСХОМ-ийг 2 дугаар сарын 10-ны өдөр мэдүүлсэн. | 01/02-12/30 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар 1. | Саналын тоо | - | 4 | Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн захирлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/45 дугаар тушаалаар байгуулагдсан Мэдээлэл, харилцааны холбооны технологийн чиглэлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх комиссын бүрэлдэхүүнд ажилласан:<br>1.Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөс 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр | 04/01-05/30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан хуралд оролцож, ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургууль, МУИС-ийн Мэдээллийн технологи, электроникийн сургууль, Шинжлэх ухаан академийн дэргэдэх их сургууль зэрэг 4 сургуулийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд санал, зөвлөмж өгсөн.<br>2. 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд оролцож, ШУТИС-ын харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн Дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд санал, зөвлөмж өгсөн. | | |
| 2. | Үүрэг даалгавар 2. | Хүргүүлсэн тайлбарын тоо | - | 1 | Мэдээлэл холбооны операторуудын ассоциациас Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд хандаж Нам орбитын хиймэл дагуулын Старлинк интернэтийн үйлчилгээ, энэхүү үйлчилгээтэй холбоотой газрын станцыг Монгол Улсад байгуулах талаар байр сууриа илэрхийлсэн албан бичгийг судалж, холбогдох тайлбарыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02/937 дугаар албан бичгээр Ерөнхийлөгчийн тамгын газар болон Мэдээлэл холбооны операторуудын ассоциацид хүргүүлсэн. | 02/10-04/23 | 100 |
| 3. | Үүрэг даалгавар 3. | Зохион байгуулсан уулзалтын тоо | - | 2 | 1.Авлигатай тэмцэх газраас Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой тодруулга авах хүсэлтийн дагуу АТГ, ХХЗХ-ны холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтын хүрээнд яригдсан асуудалтай холбогдуулан нэмэлт мэдээлэл бэлтгэж, byambadorj@jaac.mn цахим шуудангаар хүргүүлсэн.<br>2.ЦХХХ-ны сайдын 2024 оны А/29 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаар болон Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт (Toll free)-ын ялгаа, зааг болон Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан зөвлөмж | 04/01-05/05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | /ITU-T E.161.1/-ийн талаар мэдээлэл өгч, санал солилцов. Уулзалтад тус газрын дарга Ш.Батзаяат, ахлах шинжээч Б.Эрдэнэ, ХХЗХ-ны Зохицуулалтын газрын ЗХХ-ийн дарга А.Уранчимэг, мэргэжилтэн Сувд-Эрдэнэ нар оролцов. | | |
| 4. | Үүрэг даалгавар 4. | Ярианы сэдвийн тоо | - | 1 | ЦХИХХ-ны сайд Ц.Баатархүү БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шэнь Миньжуань-тай уулзах уулзалтын ярианы сэдэвт санал боловсруулж, ГХАХ-т цахим шуудангаар хүргүүлсэн. | 03/20-03/27 | 100 |
| 5. | Үүрэг даалгавар 5. | Тушаалын төслийн тоо | - | 1 | Нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглах талаар судалгаа хийж, холбогдох баримтлах чиглэлийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын мэдээллийг авахаар 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 02/1153 дугаар бүхий албан бичгийг 16 байгууллагад хүргүүлж, улмаар Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулсан. | 05/12-05/25 | 100 |
| 6. | Үүрэг даалгавар 6. | Саналын тоо | - | 1 | Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Харилцаа холбооны тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал өгч ажилласан. | 05/15-05/30 | 100 |
| 7. | Үүрэг даалгавар 7. | Санал, дүгнэлтийн тоо | - | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар байгуулсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх" үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, Монголын цахилгаан холбоо компанийн Бизнес төлөвлөгөө болон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хяналт хийж, холбогдох дүгнэлтийг Ажлын хэсэгт хүргүүлсэн. | 01/02-04/30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцох | Хурал, зөвлөгөөний тоо | - | 2 | 1.Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооноос 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан хуралд оролцож, Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр тус яамны эрхлэх асуудлын хүрээнд салбар хуралдаан зохион байгуулахтай холбоотой мэдээлэл авч, удирдлагыг мэдээллээр хангасан.<br>2.ХХЗХ-оос 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын бодлого, зохицуулалт” хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл авсан. | 02/01-05/30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх, мэргэшлийн дагуу сургалт, семинарт хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | 1.Ази номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас 2025 оны 02 дугаар сарын 26-аас 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрүүдэд Японы Токио хотноо зохион байгуулсан “Цахимжилтын эрин үед Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан хүмүүсийн амьдралыг сайжруулах нь” сэдэвт сургалтад хөтөлбөрийн дагуу оролцож, 03 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн хөгжил, төрөөс баримталж буй бодлого, статистик мэдээллийн талаар илтгэл танилцуулсан. Томилолтоор ажилласан тухай тайланг ГХАХ-т зохих хугацаанд хүргүүлсэн. | 02/25-03/07 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Харилцаа холбооны хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч
*( Албан тушаал )*

Б. Эрдэнэ / ............................ /
*( Нэр, гарын үсэг )*

2025. 06. 10.
*( Огноо )*